



## БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 01 сарын 13 өдөр

Дугаар 422

Булган сум

### “Цахим Булган” хөтөлбөр боловсруулах ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, 60.1.21 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалт, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2022 оны 5 дугаар сарын 18-ны өдрийн А/24 дүгээр тушаалаар батлагдсан “Цахим үндэстэн” баримтлах чиглэл, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны IV хуралдааны аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны “Булганы сэргэлт” хөтөлбөрийг батлах тухай IV/25 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны “Булганы сэргэлт” хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх “Цахим Булган” хөтөлбөрийг боловсруулах ажлын хэсгийг доорх бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн дарга: Д.Наранбаяр (Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэч)

Гишүүд: Б.Одхүү (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга)

Д.Батцогт (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга)

Г.Давааням (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга)

Б.Энхмаа (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн Цахим үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн)

Б.Нямсүрэн (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн Мэдээллийн технологийн ажилтан)

Ч. Амгалан (Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга)

А.Гантөмөр (Байгаль орчны газрын дарга)

Ү.Бямбасүрэн (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга)



Д.Лхагвасүрэн (Татварын газрын дарга)  
Ц.Энх-Амгалан (Нийгмийн даатгалын газрын дарга)  
Н.Батжаргал (Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга)  
Ж.Ганболд (Улсын бүртгэлийн хэлтсийн дарга)  
Д.Эрдэнэхүү (Цагдаагийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Дэд бөгөөд эрүүгийн цагдаагийн тасгийн дарга, цагдаагийн дэд хурандаа)  
Б.Жавхлантөгс (Тагнуулын ерөнхий газрын Булган аймаг дахь хэлтсийн дарга, хурандаа)  
П.Оюунцэцэг (Эрүүл мэндийн газрын дарга)  
Б.Мөнхгэрэл (Боловсролын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)  
Н.Булган (Булган аймаг дахь ТЦҮХ-ийн дарга)  
Ч.Оюун ("Мэдээлэл холбооны сүлжээ" ХХК-ийн дарга)  
Т.Золзаяа (Монголын цахилгаан холбоо ХК-ийн захирал)  
Ю.Батдорж (Монгол шуудан ХК-ийн дарга)  
Д.Бямбажаргал (Булган сумын Засаг дарга)  
Б.Билгүүн ("Ашин" ХХК-ийн захирал)  
Нарийн бичгийн дарга: Д.Эрдэнэбилэг (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга)

2. "Цахим Булган" хөтөлбөрийг хууль журмын дагуу оновчтой боловсруулж, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанд танилцуулж, 2025 оны I улиралд батлуулахыг ажлын хэсгийн дарга (Д.Наранбаяр)-д даалгасугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан Аймгийн Засаг даргын 2025 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн А/22 дугаар захирамжийг хүчингүй болгосонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР

